

SMG Үйлчилгээ **Глобал нууцлалын бодлого**

Хүчинтэй болж эхлэх хугацаа: 2018 оны гуравдугаар сар

Энэхүү Нууцлалын бодлого нь энэ вэбсайт болон энэ Нууцлалын бодлогыг нийтэлсэн, холбоос өгсөн эсвэл иш татсан бусад вебсайт, үйлчилгээ, гар утасны аппликейшн зэргээр дамжуулан цуглуулсан Хувийн мэдээллийн SMG боловсруулалтанд хамаарна (хамтад нь **"SMG Services"**). "Хувийн мэдээлэл" гэдэг нь тодорхой хүнтэй эсвэл танигдаж болох хүнтэй холбоотой мэдээлэл юм. Service Management Group, LLC, Service Management Group Limited, Service Management Group GK ба тэдгээрийн салбарууд нь SMG Үйлчилгээг өмчилж ажиллуулдаг (хамтад нь **"SMG,"** "бид" эсвэл "бид нар"). Нууцлалын бодлогод таны Хувийн мэдээллийг хэрхэн цуглуулж, боловсруулдаг тухай тусгасан байна.

ЭНЭХҮҮ НУУЦЛАЛЫН ТАЛААРХ МЭДЭГДЛИЙГ АНХААРАЛТАЙ УНШИНА УУ. Таны Хувийн мэдээллийг энэхүү Нууцлалын бодлогод тодорхойлсны дагуу цуглуулж боловсруулна.

Хэрэв та харж амжаагүй байгаа бол манай вэбсайт, програм, үйлчилгээ болон гар утасны програмын хэрэглээг зохицуулах нөхцөл зэргийг тодорхойлсон SMG-ийн Үйлчилгээний нөхцөлийг ("SMG Үйлчилгээ") уншина уу.

ХЭРЭВ ЭНЭХҮҮ НУУЦЛАЛЫН БОДЛОГО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛИЙН АЛЬ НЭГ ХЭСЭГТЭЙ ТА САНАЛ НИЙЛЭХГҮЙ БОЛ SMG ҮЙЛЧИЛГЭЭГ БҮҮ ХЭРЭГЛЭ.

1. **НУУЦЛАЛЫН БОДЛОГОД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТ**
2. **SMG-ИЙН БОЛОВСРУУЛДАГ ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ**
3. **БИД МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН ЦУГЛУУЛДАГ БА МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТЫН ЗОРИЛГО**
4. **БОЛОВСРУУЛАЛТЫН ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ**
5. **БИД ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АШИГЛАЖ ХУВААЛЦДАГ ВЭ**
6. **ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН ХАДГАЛАЛТ БА УСТГАЛ**
7. **ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН БОЛОВСРУУЛАЛТЫН ТАЛААРХ ТАНЫ ЭРХ БА СОНГОЛТ**
8. **ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭ ӨГӨХГҮЙ БАЙХЫН ҮР ДАГАВАР**
9. **КҮҮКИЙН ТАЛААРХ БОДЛОГО**
10. **ӨӨРИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЛЭЭ ЗОХИЦУУЛАХ**
11. **ХҮҮХДЭД ХАМААРАХ НУУЦЛАЛ**
12. **ГУРАВДАГЧ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИД ХАНДАХ ХОЛБООС**
13. **МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ**
14. **ГАЗАР ЗҮЙН БАЙРЛАЛААС ХАМААРАХ ОНЦЛОГ БА ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХИЛ ДАВУУЛАН ДАМЖУУЛАХ**
15. **ХОЛБОО БАРИХ**
16. **МЭДЭЭЛЛИЙН ХЯНАЛТ БА АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАРИУЦСАН АЖИЛТАН**

1. ЭНЭХҮҮ НУУЦЛАЛЫН БОДЛОГОД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТ

Шинэ үйлчилгээ, програм нэмэх, үйлчилгээ сайжруулах, технологи, хуулийн өөрчлөлт зэрэг Нууцлалын бодлогод нөлөөлөхүйц өөрчлөлт оруулах тухай бүрт энэхүү Нууцлалын бодлогыг шинэчилж байх болно. Энэхүү Нууцлалын бодлогын Хүчинтэй болж эхлэх хугацааг цахим хуудасныхаа дээд хэсэгт байрлуулсан бөгөөд Нууцлалын бодлогыг сүүлд шинэчилсэн огноог харуулсан болно. Хэрэв томоохон өөрчлөлт оруулсан бол SMG таньд мэдэгдэх ба шаардлагатай бол зохих хуулийн дагуу танаас

зөвшөөрөл авна. Мэдэгдлийг өгөхдөө манай вэбсайт, эсвэл програмуудаар дамжуулан өөрчлөлтийн тухай мэдэгдэл нийтэлнэ.

2. SMG-ИЙН БОЛОВСРУУЛДАГ ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ

SMG нь бараа, үйлчилгээнийхээ талаар хэрэглэгчийн хүсэл сонирхлыг илүү ойлгохыг хүсч буй компаниудын нэрийн өмнөөс зах зээлийн судалгаа явуулдаг. Эдгээр компаниуд нь бидний **"Үйлчлүүлэгчид"** юм. Бид Үйлчлүүлэгчдийнхээ өмнөөс судалгаа явуулдаг (нийтэд нь **"Судалгаа"** гэнэ) ба судалгаагаар олсон мэдээллийг ашиглан хэрэглэгчид хаана, хэзээ, хэдэн удаа жижиглэн худалдааны дэлгүүрт очдог болох, мөн тэдний дэлгүүр орох үеийн туршлагын талаар ойлголт авдаг. Таныг судалгаанд оролцох эсвэл SMG-ийн Үйлчилгээг авах үед бид таны сайн дураараа өгөх Хувийн мэдээллийг цуглуулна.

Бидний цуглуулдаг Хувийн мэдээлэлд дараах зүйлс багтана: (1) холбоо барих мэдээлэл (и-мэйл хаяг, утасны дугаар, ажлын газар г.м.); (2) хүн ам зүйн мэдээлэл (хүйс, төрсөн огноо, шуудангийн код); (3) судалгааны асуумжинд өгсөн хариултууд (эдгээр хариултанд үндэслэн таныг тодорхой хэмжээнд таних боломжтой); (4) таны SMG Үйлчилгээг ашиглаж байгаатай холбоотой мэдээлэл ("Хэрэглээний талаарх мэдээлэл").

Бидний цуглуулдаг Хэрэглээний талаарх мэдээлэл: (1) IP хаяг; (2) домэйн сервер; (3) үйлчилгээнд хандахад ашигладаг төхөөрөмжийн төрөл; (4) таны хөтөч ба төхөөрөмжийн харилцан үйлчлэлтэй холбоотой мэдээлэл буюу төхөөрөмжийн загвар, үйлчилгээ үзүүлэгч/сүлжээ, батарейн үлдсэн хугацаан дээр үндэслэн батарейн мэдээллээр байрлал турших, таны төхөөрөмжийн үндсэн хэрэглээний статистик үзүүлэлтүүд; (5) бодит цагийн GPS буюу таны төхөөрөмж дээрх байршлын тохиргооноос мэдээлэл авах боломжийг бидэнд олгох үед газар зүйн байршлын өгөгдлүүд; (6) Та Үйлчилгээг авахдаа хэрэглэсэн вэбсайт, бусад эх сурвалжийг заах. Та Судалгаанд онлайнаар оролцох үед залиланг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор бид таны төхөөрөмжийн хэд хэдэн өвөрмөц шинж чанарын талаар мэдээлэл цуглуулдаг.

3. БИД МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН ЦУГЛУУЛДАГ БА МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТЫН ЗОРИЛГО

Таны өгсөн мэдээлэл болон та SMG Үйлчилгээг авах үед бид мэдээлэл цуглуулж, боловсруулдаг. Бидний цуглуулсан мэдээлэл, түүнийг хэрхэн боловсруулах нь та SMG Үйлчилгээнд хэрхэн хандаж, ашиглаж байгаагаас хамаарна.

Таниас. Бид таниас дараах үед мэдээлэл цуглуулдаг:

- **Судалгааны асуумжинд хариулах үед:** Судалгааны асуумжинд хариулсан мэдээлэлд үндэслэн хэрэглэгчийн дадал туршлага болон сонголтын талаархи мэдээллийг цуглуулдаг. Хэрэглэгчийн дадлыг илүү сайн ойлгохын тулд Судалгааны асуумжинд хариулсан хариултаас гаргаж авсан мэдээллийг 'Байнгын хэрэглэгч' хөтөлбөрт оролцсон тухай мэдээлэлтэй нэгтгэн, улмаар таны хэрэглэгчийн дадал туршлагыг илүү сайн ойлгох боломжтой болно. Түүнчлэн бид Судалгаагаар таниас болон бусад хэрэглэгчдээс авсан мэдээллийг нэгтгэж, нийт хэрэглэгчдийн дада туршлагын талаар илүү сайн ойлгох боломжтой болно. Таныг судалгааны асуумжинд хариулж дууссаны дараа таны бидэнд өгсөн мэдээллийг бид хэрэглэгчдийн туршлага болон сонголтын талаарх тайлан болон бусад дүн шинжилгээнд ашиглах ба мэдээллийг цуглуулж байх үед танд мэдэгдсэний дагуу бусад зорилгоор ашиглана. Хэрэв та өөрийнхөө өгсөн мэдээллийг тайлан, дүн шинжилгээ болон танд мэдэгдсэний дагуу бусад зорилгоор ашиглуулахыг хүсэхгүй байгаа бол та Судалгаанд оролцохгүй байх сонголт хийж болно.

- **SMG Үйлчилгээг авах.** Таныг SMG Үйлчилгээг авах үед бид күүки болон мэдээлэл цуглуулах бусад хэрэгслээр дамжуулан автоматаар Хэрэглээний талаарх мэдээллийг цуглуулах болно. Бид энэхүү Хэрэглээний талаарх мэдээллийг таны төхөөрөмж болон манай системийн хоорондын харилцаа холбоог дэмжих, Судалгааг хүргэх, Судалгааны шударга байдлыг хангах, залиланг илрүүлэх ба сэргийлэх, зах зээлийн судалгаа явуулах, вэбсайт ба програм хангамжийг сайжруулах, SMG Үйлчилгээний ашиглалтыг шинжлэх, сайжруулах зэрэгт ашигладаг. Күүки болон өгөгдөл цуглуулах бусад ижил төрлийн хэрэгслийг бид яаж, яагаад ашигладаг талаар тодорхой мэдэхийг хүсвэл энэхүү Нууцлалын бодлогын "Күүкийн бодлого" хэсгийг үзнэ үү.
- **SMG Үйлчилгээг авч байх явцад өөрийн Хувийн мэдээллийг явуулах:** SMG Үйлчилгээг авах үед Хувийн мэдээллээ явуулах, эсвэл тусламж, мэдээлэл авахаар хандах, эсхүл манай Үйлчлүүлэгчдийн аль нэгтэй харилцсан туршлагынхаа тухай саналаа хэлэхээр бидэнтэй холбогдох үед бид таны өгсөн мэдээллийг цуглуулж шинжилнэ. Та SMG-д санал бодлоо хуваалцсанаар таны өгсөн мэдээлэл манай Үйлчлүүлэгчдэд үзүүлж буй үйлчилгээ ба ерөнхий зах зээлийн судалгаанд дөхөм болдог. Таны зөвшөөрөлтэйгээр таны саналыг TrumpetRatings.com-д болон/эсвэл манай Үйлчлүүлэгчийн вэбсайтад байрлуулж болно. Ийм мэдээллийг TrumpetRatings.com шиг нээлттэй форум, эсвэл олон нийтэд хүртээмжтэй бусад вэбсайтуудад нийтэлвэл энэ нь нээлттэй мэдээлэл болно. Таны бичсэн зүйлсийг гуравдагч этгээд харах эсвэл цуглуулснаар энэ нь бидний хянах эсвэл урьдчилан мэдэх боломжгүй арга замаар бусдад ашиглагдаж болно.
- **Social Media Credentials-ээр дамжуулан SMG Үйлчилгээнд хандах:** Зарим SMG үйлчилгээг авахын тулд нийгмийн сүлжээний үйлчилгээг (нийтэд нь "Нийгмийн Сүлжээ") ашиглах боломжийг SMG таньд олгож болно. Та Нийгмийн сүлжээнд нэвтрэх эрхээрээ дамжуулан SMG Үйлчилгээнд хандах үед SMG нь таны нууцлалын тохиргооноос хамааран таны хэрэглэгчийн дансны нэр, имэйл хаяг, профайл зураг, нийтлэл, сэтгэгдэл гэх мэт Нийгмийн сүлжээний платформ дахь мэдээлэлд нэвтрэх боломжтой байж болно. Бид энэ мэдээллийг Нууцлалын бодлогод тодорхойлсныхоо дагуу, эсвэл мэдээллийг цуглуулж байх үед танд мэдэгдсэнийхээ дагуу аливаа өөр зорилгоор ашиглаж болно. Нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч таны мэдээллийг SMG-тэй хуваалцах явдлыг та хүсэхгүй байгаа бол SMG Үйлчилгээг авахдаа Нийгмийн сүлжээ хэрэглэгчийн дансаа ашиглах хэрэггүй.

Манай Үйлчлүүлэгчдээс. Манай зарим бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээнд манай Үйлчлүүлэгчид өөрсдийнх нь бренд, бүтээгдэхүүн, үйлчилгээ зэрэгт та хэрхэн хамрагдсан болох, тухайлбал та 'байнгын хэрэглэгч' хөтөлбөрт хамрагдсан тухай мөн тэдэнтэй хийсэн гүйлгээний талаархи мэдээлэл зэргийг бидэнд илгээж болно. Бид энэхүү мэдээллийг зах зээлийн судалгаа болон Үйлчлүүлэгчиддээ үзүүлж буй үйлчилгээг сайжруулах зорилгоор цуглуулсан бусад мэдээлэлтэй нэгтгэж болно.

4. БОЛОВСРУУЛАЛТЫН ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

- 4.1. Судалгааны асуумжинд хариулах болон SMG Үйлчилгээг авах үед бид таны харилцах хаяг, хүн ам зүйн мэдээлэл, судалгааны асуумжийн хариулт зэргийг цуглуулж боловсруулдаг. Бид худалдан авагчдынхаа ашиг тусын тулд манай Үйлчлүүлэгчдийн үйлчилгээгээ сайжруулах гэсэн хууль ёсны ашиг сонирхол болон SMG-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, зах зээлийн судалгаа, хэрэглэгчийн хүсэлт, тэдэнд үзүүлэх тусламжаа сайжруулах гэсэн SMG-ийн хууль ёсны ашиг сонирхолд тулгуурлан дээрх Хувийн мэдээллийг боловсруулдаг.

- 4.2. Судалгааны асуумжинд хариулах эсвэл SMG Үйлчилгээг авах үед бид таны Хэрэглээний талаарх мэдээллийг боловсруулдаг. Та судалгаанд оролцохоор сонголт хийсэн тохиолдолд таниас SMG-ийн күүки болон мэдээлэл цуглуулах бусад технологийг ашиглах зөвшөөрлийг авч, улмаар Хэрэглээний талаарх мэдээллийг боловсруулдаг. Та зөвшөөрлөө цуцлахыг хүссэн тохиолдолд Мэдээллийн аюулгүй байдлыг хариуцсан ажилтантай [_privacyofficer@smg.com](mailto:privacyofficer@smg.com) имейлээр холбоо барих эсвэл Data Protection Officer, Service Management Group, LLC, 1737 McGee Street, Kansas City, MO 64108. хаягаар бичгээр мэдэгдэж болно.
- 4.3. Та сошиал сүлжээний үйлчилгээг SMG Үйлчилгээтэй хослуулан хэрэглэх үед таны нууцлалын тохиргооноос хамааран таны Сошиал сүлжээний платформ дээр өгсөн мэдээллийг бид боловсруулж болно. Ийм төрлийн мэдээллийг боловсруулахдаа бид таны сошиал сүлжээн дэх нууцлалын тохиргоонд оруулсан зөвшөөрөл дээр үндэслэнэ. Бидэнд Сошиал Сүлжээний мэдээлэлд нэвтрэх боломж олгохыг хүсэхгүй байгаа тохиолдолд та нууцлалын тохиргоогоо өөрчилж, дээрх зөвшөөрлийг цуцалж болно.
- 4.4. Бид таны брэнд, бүтээгдэхүүн болон үйлчилгээ зэрэг харилцааны талаарх Үйлчлүүлэгчдээс ирсэн мэдээллийг боловсруулдаг. Бид SMG-ийн болон SMG-ийн Үйлчлүүлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сайжруулж, илүү өндөр шатанд хүргэх гэсэн хууль ёсны ашиг сонирхолд үйлчлэх, мөн , SMG-ийн зах зээлийн судалгааг сайжруулахыг зорьж иймэрхүү мэдээллийг боловсруулдаг.

5. БИД ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АШИГЛАЖ ХУВААЛЦДАГ ВЭ

Бид таниас цуглуулсан эсвэл таны бидэнд өгсөн мэдээллийг яаж ашиглах, хуваалцах нь таны SMG Үйлчилгээнд хэрхэн хандаж, ашиглаж буйгаас хамаарна. Хуулийн дагуу шаардлагатай тохиолдолд SMG нь таны хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд өгөхийг зогсоох хүсэлтийг тань биелүүлнэ.

- **Таньтай холбоо барих.** Хэрэгтэй үед таньтай шуудан, утас, цахим шуудан, хөдөлгөөнт дохиолол, SMS текст мессежээр холбоо барихын тулд таны хувийн мэдээллийг ашиглана. Судалгаанд оролцогчийн зүгээс холбоо барих хүсэлт гаргаагүй бол SMG нь судалгаанд оролцогчидтой судалгааны шударга байдлыг хангах, Судалгааг хүргэх, судалгаанд оролцсоны урамшуулал шагналыг олгох, эсвэл үйлчилгээ үзүүлэх зэрэг шаардлагаас өөр шалтгаанаар холбоо барихгүй. Хэдийгээр SMG таны Хувийн мэдээллийг шууд маркетингийн зорилгоор ашиглахгүй хэдий ч таны Хувийн мэдээллийг дамжуулах гэж байгаа үйлчлүүлэгчийн Нууцлалын бодлогыг та тоймлож харах нь зүйтэй. Бид таны Хувийн мэдээллийг таньтай харилцахад тусалдаг үйлчилгээ үзүүлэгчидтэй хуваалцаж болно.
- **Таны хүсч буй Үйлчилгээг үзүүлэх.** Бид таны хүссэн үйлчилгээг үзүүлэх, эсвэл мэдээллийн самбар, форум болон манай Сошиал сүлжээний хуудсанд мэдээлэл, материал байрлуулахыг хүссэн үед таны Хувийн мэдээллийг ашиглаж, хуваалцаж болно. Түүнчлэн, та зөвшөөрвөл SMG Үйлчилгээгээр дамжуулан таны холбоо барьж байгаа аливаа хүнд таны Хувийн мэдээллийг ил болгоно. Цаашилбал, бид таньд Судалгаанд оролцож хүртсэн шагнал урамшууллыг хүргэхийн тулд таны Хувийн мэдээллийг ашиглах ба гуравдагч этгээдтэй хуваалцаж болно. Хэрэв та сугалаа эсвэл бусад урамшуулалд оролцохыг сонгосон бол бид таны мэдээллийг эдгээр урамшууллыг үзүүлдэг гуравдагч этгээдийн администратор руу илгээх ба ингэснээр тэд таны асуусан асуултанд хариулж, таны хожсон шагнал урамшууллын талаар таньтай холбоо барих болно.

- **SMG Үйлчилгээний ашиглалтыг шинжлэх ба сайжруулах.** Бид SMG үйлчилгээнд ашиглалтын анализ хийх, залилан илрүүлэлт болон гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор күүки ба мэдээлэл цуглуулах бусад хэрэгслээс гаргаж авсан Хувийн мэдээллийг ашигладаг. Бид гуравдагч этгээдийн вэбсайтын аналитик үйлчилгээг ашиглан хүмүүс хулганы товч, хулганы хөдөлгөөн, гүйлгэж харсан байдал, чөлөөт хэлбэрийн бичвэрийн хайрцагт бичдэг текст зэрэг SMG үйлчилгээг хэрхэн ашигладаг талаар дүн шинжилгээ хийж болно. Бид манай хэрэглэгчид SMG Үйлчилгээг яаж олж хэрэглэдэг талаар илүү ойлголттой болох, мөн үйлчилгээгээ сайжруулах, хэрэглэгчийн туршлагыг сайжруулахын тулд эдгээр гуравдагч этгээдийн үйлчилгээнээс цуглуулсан мэдээллийг ашигладаг.
- **Бусад Үйлчилгээ үзүүлэгчидтэй мэдээллийг хуваалцах.** Бид хостинг хийх, мэдээлэл хадгалах, аюулгүй байдлыг хангах зэрэг ажлыг гүйцэтгүүлдэг бусад үйлчилгээ үзүүлэгчидтэйгээ таны мэдээлэл, түүний дотор хувийн мэдээллийг хуваалцаж болно. Бидний ажиллуулж буй вэбсайтууд дээрх үнэлгээ, сэтгэгдлүүд зэрэг SMG үйлчилгээг явуулахын тулд хэрэгтэй гэж үзвэл таны Хувийн мэдээллийг бид хуваалцаж магадгүй.
- **Үйлчлүүлэгчидтэй мэдээлэл хуваалцах.** Хэрэв та манай Үйлчлүүлэгчдийн аль нэгний тухай хэрэглэгчийн сэтгэгдлээ хуваалцахаар судалгаанд оролцох журмаар SMG Үйлчилгээг авсан бол Судалгааны асуумжинд хариулахдаа өгсөн Хувийн мэдээллийг бид Үйлчлүүлэгчтэй хуваалцах болно. Мөн энэхүү Хувийн мэдээллийг зах зээлийн судалгааны гаргалгаа хийх, хэрэглэгчийн зан төлөвийн дүн шинжилгээ, бизнесийн тандалтын үр дүнг Үйлчлүүлэгчид хүргэх зорилгоор ашиглана. Үйлчлүүлэгч бидний цуглуулж өгсөн Хувийн мэдээллийг хэрхэн ашиглаж, хамгаалж, боловсруулдаг тухай мэдээлэл авахыг хүсвэл тухайн Үйлчлүүлэгчийн нууцлалын бодлогын талаар уншаарай. Бид болон манай Үйлчлүүлэгчид өөр өөр төрлийн мэдээллийг, тухайлбал танаас, эсвэл бид болон манай Үйлчлүүлэгч эсвэл гуравдагч этгээдийн эх сурвалжаас таны тухай цуглуулсан Хувийн мэдээллийг нэгтгэж болно. SMG нь энэхүү Нууцлалын бодлогод тодорхойлсон зорилгоор, мөн манай Үйлчлүүлэгчийн нууцлалын бодлогод тодорхойлсон зорилгоор нэгтгэсэн мэдээллийг ашиглаж болно.
- **Эрх зүйн үүргээ биелүүлэх, хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх.** Мөн шаардлагатай үед өөрийн эрхээ хэрэгжүүлэх, өмч хөрөнгө эсхүл эрхээ хамгаалах, бусдын эд хөрөнгө, аюулгүй байдлыг хамгаалах, эсвэл хөндлөнгийн аудит, хууль журмын мөрдөлт болон компанийн засаглалын үүргийг дэмжих зорилгоор бид таниас цуглуулсан мэдээллийг хуваалцаж болно. Бид мэдээлэл хамгааллын эрх бүхий байгууллага эсхүл шүүхийн заавал биелүүлэх шийдвэр, шүүх хурлын зарлан дуудах бичиг, засгийн газар эсвэл бусад эрх зүйн эсвэл зохицуулагч байгууллагын хүсэлтийн дагуу шаардлагатай гэж үзвэл Хувийн мэдээллийг ил болгоно. Аль ч тохиолдолд энэ нь таны оршин суугаа улсаас гадуурх байгууллага байж болно. Бид мөн манайд учирч болох хор хохирлыг барагдуулах эсхүл багасгах зорилгоор Хувийн мэдээллийг хуваалцаж болно.
- **Компанийн бүтцийн өөрчлөлт хийхтэй холбоотойгоор мэдээллийг Шилжүүлэх.** Аливаа дампуурал буюу үүнтэй төстэй үйл явцын улмаас SMG болон харьяа байгууллага (бүхэлдээ эсвэл хэсэгчлэн) одоо цагт эсхүл ирээдүйд өөрчлөн байгуулагдах, нэгдэх, борлогдох, хамтарсан үйлдвэр байгуулах, шилжүүлэх, худалдан авах, эсвэл өмчлөх эрх, удирдлагын бусад өөрчлөлт гарах болсонтой холбоотойгоор бид таны Хувийн мэдээллийг дамжуулж болно. Биднээс Хувийн мэдээллийг шилжүүлж авсан аливаа байгууллага нь энэхүү Нууцлалын бодлогод тусгагдсан зорилгод нийцэхгүй, эсвэл нууцлалын практик нь энэ Нууцлалын бодлогод тусгагдсанаас өөр бол танд энэ тухай мэдэгдэл

очсон байх шаардлагатай. Хуулинд заасны дагуу ийм байгууллага нь таниас зөвшөөрөл авах шаардлагатай.

- **Хувийн мэдээллийг бизнесийн бусад зорилгоор ашиглах.** Бид таны Хувийн мэдээллийг SMG Үйлчилгээг үзүүлэх, бүтээгдэхүүн болон үйлчилгээг хөгжүүлэх зэрэг бизнесийн бусад хууль ёсны зорилгоор ашиглаж болно.

6. ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН ХАДГАЛАЛТ БА УСТГАЛ

Бид таны Хувийн мэдээллийг өөрийн бүртгэлд хадгалахдаа мэдээллийг анх цуглуулахад тавьсан зорилгодоо хүрэхэд шаардлагатай хугацааг хэтрүүлэхгүй байхыг зорино. Мэдээллийг анх цуглуулсан үеийн зорилгоор ашиглагдахаа больсон үед, хэрэв бидний хууль зүйн үүргээ биелүүлэхэд шаардлагатай биш бол, таны Хувийн өгөгдлийн цахим хуулбарыг бид аюулгүй байдлаар устгаж, мөн Хувийн мэдээлэл бүхий цаасан хуулбарыг найдвартайгаар хэрчиж устгана.

7. ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН БОЛОВСРУУЛАЛТЫН ТАЛААРХ ТАНЫ ЭРХ БА СОНГОЛТ

Та SMG Үйлчилгээг авахаа больсноор аль ч үед Судалгаанд оролцохоо зогсоож болно.

Хэрэв та өөрийн Хувийн мэдээлэлтэй холбоотой тусгай арга хэмжээ авах хүсэлт гаргах эрх олгосон хууль тогтоомж бүхий газарт оршин сууж байгаа бол тухайн хууль дүрэм эсвэл журмын дагуу танд олгогдсон дараах тусгай эрхийг эдлэнэ. Үүнд: өөрийнхөө Хувийн мэдээллийг үзэх, засварлаж зөв болгуулах (нэмэлт өөрчлөлт оруулах), Хувийн мэдээллийг арилгуулах, хувийн мэдээллийг шилжүүлэх (өөрөөр хэлбэл, мэдээллийн зөөвөрлөлт), Хувийн мэдээлэл боловсруулалтыг хязгаарлах, мөн түүнчлэн боловсруулалт хийхийг эсэргүүцэх, зөвшөөрлөө эргүүлэн татах, бүртгэлийн дансаа хүчингүй болгох, хяналтын байгууллагад гомдол гаргах зэрэг эрхтэй. Эдгээр бүх хүсэлтийг холбогдох хууль тогтоомжид заасан үзүүлэлтүүдийн дагуу зохицуулна.

Хэрэв та Европын Холбоонд оршин суудаг бол, Мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах тухай ерөнхий журмын дагуу өөрийнхөө хувийн мэдээллийг үзэх, засварлаж зөв болгуулах, хувийн мэдээллийг арилгуулах, хувийн мэдээллийн зөөвөрлөлт, хувийн мэдээлэл боловсруулалтыг хязгаарлах, мөн түүнчлэн таны хувийн мэдээлэлд боловсруулалт хийхийг эсэргүүцэх, зөвшөөрлөө эргүүлэн татах ба хяналтын байгууллагад гомдол гаргах зэрэг эрхтэй байна. Хэрэв та Европын холбооноос гадуур оршин суудаг бол орон нутгийхаа хуулийн дагуу мэдээллийн талаар тодорхой эрхтэй байх ёстой.

Ийм хүсэлт гаргахын тулд та манай Мэдээллийн аюулгүй байдлыг хариуцсан ажилтантай и-мэйлээр privacyofficer@smg.com хаяг руу, эсвэл Data Protection Officer, Service Management Group, LLC, 1737 McGee Street, Kansas City, MO 64108 хаягаар бичиж холбоо барина уу.

8. ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭ ӨГӨХГҮЙ БАЙХЫН ҮР ДАГАВАР

Хэдийгээр бидний судалгаанд оролцох нь сайн дурын хэрэг боловч та Судалгааны хүрээнд хүссэн бүх мэдээллийг өгөхгүй бол тодорхой урамшуулал, шагналыг хүртэх шалгуурыг хангаж чадахгүй.

9. КҮҮКИЙН ТАЛААРХ БОДЛОГО

9.1. Күүки гэж юу вэ

SMG болон манай үйлчилгээ үзүүлэгчид күүки гэж нэрлэдэг жижиг текст файл ашигладаг. "Күүки" нь Үйлчилгээг ашиглаж байх үед таны компьютерийн хөтчөөс эсвэл таны компьютер, хөдөлгөөнт төхөөрөмж эсвэл таблет компьютерын хатуу дискээс явуулсан жижиг компьютер файлууд бөгөөд таны хэрэглэгчийн ID, хэрэглэгчийн тохиргоо, вэб хөтчийн түүх, үйл ажиллагаануудыг агуулсан байдаг. Күүки ихэвчлэн Күүки үүсгэгдсэн домэйн нэр (интернетийн байршил), Күүкийн амьдрах хугацаа (ө.х. хугацаа дуусах), мөн санамсаргүй үүсгэсэн өвөрмөц дугаар эсвэл таних кодыг агуулдаг. Күүки нь Хувийн мэдээлэлтэй холбогдсон байж болно.

9.2. Бид Күүки болон Мэдээлэл цуглуулах хэрэгслүүдийг хэрхэн ашигладаг вэ

Күүки нь таны навигацийн зуршлуудыг дагаж SMG Үйлчилгээг таньд тохируулах замаар SMG Үйлчилгээг сайжруулахад тусалдаг. Энэ нь SMG Үйлчилгээний техникийн болон навигацийн мэдээллийг шинжлэх боломж олгож, залиланг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд бидэнд тусалдаг.

Бид бас таныг буцаж зочлоход санах, танд илүү хамааралтай контентыг харуулах зэргээр SMG Үйлчилгээг авах туршлагыг тань сайжруулахын тулд **"Мэдээлэл цуглуулах хэрэгсэл"** гэж нэрлэдэг Күүки болон Мэдээлэл цуглуулах бусад хэрэгсэл (вэб дохио, серверийн бүртгэл гэх мэт)-ийг ашигладаг.

SMG Үйлчилгээ нь Мэдээлэл цуглуулах хэрэгслийн тусламжтайгаар таны SMG үйлчилгээг авахын тулд ашигладаг төхөөрөмжөөс үйлдлийн системийн төрөл, хөтчийн төрөл, домэйн, системийн бусад тохиргоо, системийн ашигладаг хэл, төхөөрөмжийн байрласан улс орон, цагийн бүс зэрэг мэдээлэл цуглуулж болно.

9.3. Таны Күүкийн хяналт

Вэб хөтчүүд нь вэб хөтчийн тохиргоогоор дамжуулан ихэнх күүкийг хянах боломжийг олгодог. Зарим вэб хөтчүүд (гар утасны вэб хөтөч гэх мэт) нь Күүкийг таны компьютер, таблет эсвэл хөдөлгөөнт төхөөрөмж дээр байрлуулах үед танд сэрэмжлүүлэг өгөх, мөн Күүкигээс татгалзах тохиргоо хийх боломжийг олгодог. Та зөөврийн хэрэгслийнхээ зохих тохиргоог идэвхжүүлснээр зөөврийн хэрэгслийн танигдах ялгуурыг ашиглахгүй байж болно. Та SMG-ийн Күүки болон зөөврийн хэрэгслийн ялгуурыг ашиглах явдлыг зөвшөөрөх албагүй ч хэрэв та тэдгээрийг блоклох эсвэл ашиглахаас татгалзвал SMG Үйлчилгээгээр дамжуулан авах бүх боломжийг ашиглаж чадахгүй байдалд хүрч болно. Үүнээс гадна, хэрэв манай вэбсайт болон / эсвэл аппликейшн дээр күүкийг ашиглах таны зөвшөөрлийг авахыг биднээс шаардвал та тухайн вебсайт болон / эсвэл аппликейшн дээр өөрийн күүкины тохиргоог удирдах боломжтой болно. Эдгээр вэбсайт болон аппликейшны үндсэн функцийг идэвхжүүлэхийн тулд зарим күүки шаардагдахаас гадна тэдгээр күүкийг та хаах боломжгүй.

10. ӨӨРИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЛЭЭ ЗОХИЦУУЛАХ

Та тохирох SMG Үйлчилгээний хэрэглэгчийн бүртгэлийн хэсэгт орж таны тухай бидэнд байгаа мэдээллийн бодит алдааг засаж залруулж болно. Хэрэв танд Хувийн мэдээллээ үзэх ба засах тухай асуулт байвал манай Мэдээллийн аюулгүй байдлыг хариуцсан ажилтантай и-мейлээр privacyofficer@smg.com хаяг руу, эсвэл Data Protection Officer, Service Management Group, LLC, 1737 McGee Street, Kansas City, MO 64108 хаягаар бичиж холбоо барина уу.

11. ХҮҮХДЭД ХАМААРАХ НУУЦЛАЛ

SMG Үйлчилгээ нь ерөнхий хэрэглэгчдэд зориулагдсан бөгөөд бидний үйл ажиллагаа явуулж буй аль ч байрлалд насанд хүрээгүй буюу өөрсдийн Хувийн мэдээллийг

боловсруулах зөвшөөрөл олгох насанд хүрээгүй хүүхдүүдэд зориулагдаагүй болно. Бид санаатайгаар ийм хүмүүсээс Хувийн мэдээллийг нь цуглуулахгүй. Хэрэв Хувийн мэдээллийг нь боловсруулах зөвшөөрөл хууль ёсоор авах наснаас доогуур буюу насанд хүрээгүй хүүхэд эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр Хувийн мэдээллээ бидэнд өгсөн болохыг та мэдсэн бол манай Мэдээллийн аюулгүй байдлыг хариуцсан ажилтантай privacyofficer@smg.com имэйлээр эсвэл Data Protection Officer, Service Management Group, LLC, 1737 McGee Street, Kansas City, MO 64108 хаяг руу бичгээр холбоо барина уу. Хэрэв Хувийн мэдээллийг нь боловсруулах зөвшөөрөл хууль ёсоор авах наснаас доогуур буюу насанд хүрээгүй хүүхэд эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр Хувийн мэдээллээ бидэнд өгсөн болохыг бидний зүгээс илрүүлбэл ийм мэдээллийг аль болох хурдан арилгаж, тэр хүүхдийн хэрэглэгчийн бүртгэлийг дуусгавар болгох арга хэмжээ авдаг.

12. ГУРАВДАГЧ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИД ХАНДАХ ХОЛБООС

SMG Үйлчилгээ нь гуравдагч этгээдийн вэбсайт, үйлчилгээ (" **Гуравдагч этгээдийн үйлчилгээ** ") -ний холбоосыг агуулж болно. Гуравдагч этгээдийн үйлчилгээнд холбогдох холбоосыг оруулсанаар бид тэнд тавигдсан мэдээллийн чанар ба үнэн зөвийг батална гэсэн үг биш юм. Хэрэв та Гуравдагч этгээдийн үйлчилгээг авахаар шийдсэн бол та энэхүү Нууцлалын бодлогод заасан нууцлалын журмыг бус тэдний нууцлалын журмыг мөрдөнө гэсэн үг.

13. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

SMG нь Хувийн мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хадгалахад туслах зорилготой техникийн, биет болон зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлдэг мэдээллийн аюулгүй байдлын хөтөлбөртэй байна. Хувийн мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдалд учирч болзошгүй аюул заналхийллээс урьдчилан сэргийлнэ. Таны Хувийн мэдээлэл алдагдах, зүй бусаар ашиглагдах, зөвшөөрөлгүй өөрчлөлт оруулах, устгах, зөвшөөрөлгүй нэвтрэх, задлахаас хамгаална.

Гэсэн хэдий ч, Хувийн мэдээллийн боловсруулалт хийгдсэний дараа мэдээлэл алдагдах, буруу ашиглагдах, өөрчлөгдөх, хакердуулах, зөрчих ба/эсвэл зөвшөөрөлгүйг гуравдагч этгээд хандах зэрэг эрсдэлтэй байна. Аль ч мэдээллийн систем эсвэл онлайн дамжуулалт бүрэн аюулгүй байна гэж байхгүй. Хувийн мэдээллийг хамгаалахын тулд SMG-ийн техникийн, биет болон зохион байгуулалтын арга хэмжээнээс гадна та өөрөө Хувийн мэдээллээ хамгаалахын тулд аюулгүй байдлын зохих арга хэмжээнүүдийг авах ёстой. Таны SMG-ийн бүртгэлийн данс эсвэл бидэнд өгсөн мэдээлэл тань хамгаалалтгүй болсон гэж үзэж байгаа бол та манай Мэдээллийн аюулгүй байдлыг хариуцсан ажилтанд и-мэйлээр privacyofficer@smg.com хаягаар эсвэл 1-800-764-0439 дугаар руу залгаж SMG-ийн Мэдээллийн аюулгүй байдлыг хариуцсан ажилтанд даруй мэдэгдэнэ үү.

14. ГАЗАР ЗҮЙН БАЙРЛАЛААС ХАМААРАХ ОНЦЛОГ БА ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХИЛ ДАВУУЛАН ДАМЖУУЛАХ

SMG нь АНУ-аас SMG Үйлчилгээг удирдаж, ажиллуулдаг. SMG нь таны Хувийн мэдээллийг Америкийн Нэгдсэн Улс, Их Британи, Япон, Ази дахь эсвэл Европын Холбоо зэрэг орнууд руу шилжүүлж, хадгалж, боловсруулж болно. Таны Хувийн мэдээлэл шилжиж байгаа улсын мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын талаарх хуулиуд нь танай улс дахь хуулиудтай адил боловсронгуй биш байж болно гэдгийг анхаарна уу. Жишээлбэл, АНУ руу шилжүүлсэн Хувийн мэдээллийн хувьд АНУ-ын холбооны болон мужийн эрх бүхий байгууллагууд хувийн мэдээлэлд нэвтрэх хууль ёсны эрхтэй байдаг.

Европын Эдийн засгийн бүсээс ("ЕЕА") АНУ руу Хувийн мэдээллийг шилжүүлэхдээ EU-US Privacy Shield журмыг баримталдаг. SMG нь манай ЕХ-АНУ-ын Privacy Shield

сертификатын тайлбарт заасны дагуу ЕХ-АНУ-ын хувийн нууц мэдээллийг цуглуулах, ашиглах, хуваалцах, хадгалахтай холбоотой зарчмуудыг дагаж мөрддөг. Privacy Shield жагсаалт [энд](#) харах. Privacy Shield-ийн талаар [энд](#) дэлгэрэнгүй үзэх. SMG-ийн үйл ажиллагааг АНУ-ын Холбооны Худалдааны комисс хянан шалгах ба Хувийн мэдээлэл шилжиж очсон гуравдагч этгээд Privacy Shield зарчмуудыг зөрчсөн байдлаар хувийн мэдээллийг боловсруулсан тохиолдолд SMG ямар нэг байдлаар хариуцлага хүлээхгүй. Харин SMG хохирол учирсан явдалд ямар нэгэн байдлаар хамааралтай бол зохих хариуцлагыг хүлээнэ. ЕЕА-ээс гадуур аливаа Хувийн мэдээллийг шилжүүлэхдээ Нууцлалын бодлого болон холбогдох бүх хуульд заасан зарчмуудыг баримтална. Хэрэв та манай Privacy Shield-ийн талаар гомдолтой байвал Мэдээллийн аюулгүй байдлыг хариуцсан ажилтанд privacyofficer@smg.com и-мэйлээр эсвэл бичгээр Data Protection Officer, Service Management Group, LLC, 1737 McGee Street, Kansas City, MO 64108 хаягаар хандана уу. Мөн бидний сонгосон маргааныг шийдвэрлэх бие даасан байгууллага болох Америкийн Арбитрын Холбоонд та үнэ төлбөргүйгээр гомдол гаргаж болох ба зарим тохиолдолд Privacy Shield-ийн арбитрын процессыг эхлүүлж болно.

Энэхүү Англи хэл дээрх нууцлалын бодлого нь SMG-ийн SMG Үйлчилгээнд хамаарах мэдээллийн нууцлалыг хамгаалах үйл ажиллагааны талаарх албан ёсны мэдэгдэл юм. Энэхүү Англи хэл дээрх нууцлалын бодлого болон өөр хэл рүү хөрвүүлсэн орчуулгын хооронд зөрүүтэй байдал гарсан тохиолдолд энэхүү Англи хэл дээрх баримт бичгийг үнэн зөвд тооцно.

Та мөн бидний сонгосон бие даасан маргааныг шийдвэрлэх байгууллага, Америкийн Арбитрын Ассоциаци (<http://go.adr.org/privacyshield.html>) гомдол, үнэ төлбөргүй, зарим тохиолдолд Нууцлалын Шийдвэрийг арбитрын процесс хэрэглэж болно.

15. ХОЛБОО БАРИХ

Хэрэв танд хувийн нууцтай холбоотой асуулт байгаа бол, мөн таны Хувийн мэдээллийг үзэх, шинэчлэх эсвэл боловсруулахтай холбоотой гомдол гаргамаар байвал манай Мэдээллийн аюулгүй байдлыг хариуцсан ажилтантай privacyofficer@smg.com и-мэйлээр холбоо барина уу.

Та мөн бидэнд дараах хаягаар бичиж болно:

Service Management Group, LLC
Attn: Data Protection Officer
1737 McGee Street
Kansas City, MO 64108

Service Management Group, Ltd.
Attn: Data Protection Officer
38-40 The Maltings
St Albans
Hertfordshire AL1 3HL
UNITED KINGDOM

Service Management Group G.K.
Attn: Data Protection Officer
2-7-16 No. 3 Komoriya Building 9F
Hamamatsu-cho, Minato-ku
Tokyo 1050013, Japan

16. МЭДЭЭЛЛИЙН ХЯНАЛТ БА АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАРИУЦСАН АЖИЛТАН

SMG-ийн цуглуулсан хувийн мэдээллийг Service Management Group, LLC, 1737 McGee Street, Kansas City, MO 64108. хянадаг. Та манай Мэдээллийн аюулгүй байдлыг хариуцсан ажилтантай privacyofficer@smg.com и-мэйлээр эсвэл бичгээр Data Protection Officer, Service Management Group, LLC, 1737 McGee Street, Kansas City, MO 64108 хаягаар холбогдоно уу.